



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01-

Улаанбаатар хот

「 Санхүүгийн болон үйл ажиллагааны」

тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, “МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн 2022 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

«Компанийн ТУЗ-ийн гишүүдийг»

сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, дахь заалт болон «МОНГОЛ ШИЛТГЭЭН» ХК-ийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ч.Амарбаатар
2. М.Ган-Эрдэнэ
3. Г.Ганчимэг
4. Д.Дагвадорж
5. Г.Мөнхбилэг
6. Б.Билгүүн

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Ж.Жаргалсайхан
2. М.Отгонбаатар
3. Д.Чанцал

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК
УЛААНБААТАР ТТЛСЭ-2587559

/Ч.АМАРБААТАР/



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Их хэмжээний хэлцэл хийх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.3, 62.1.10 дахь заалтууд, 87 дугаар зүйлийн 87.1 дэхь заалт, 88 дүгээр зүйлийн 88.2 дахь заалт болон "Монгол шилтгээн" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Монгол шилтгээн" ХК-ийн хуримтлагдсан 2.500.000.100 / хоёр тэр бум, таван зуун сая, нэг зуу / төгрөгийн өрийг хувьцаанд хөрвүүлэх нэгж хувьцааны үнийг 290 төгрөгөөр тогтоосугай.
2. "Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% - аас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл" зэрэг их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

「Компанийн өрийг хувьцаанд хөрвүүлэх」

тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, “Монгол шилтгээн” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 04 сарын 30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2.500 000 100 / хоёр тэр бум, таван зуун сая, нэг зуу / төгрөгийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн өрийг хувьцаанд хөрвүүлснээр “Монгол шилтгээн” ХК нь нэг бүр нь 290 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 8.620.690 ширхэг энгийн хувьцааг гаргасугай.
3. Өрийг хувьцаагаар солих төслийг хавсралтаар баталсугай.
4. Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г Тэргүүн ээлжид худалдан авах,
давуу эрхээ хувьцаа олгох тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.8 дахь заалт болон 25 дугаар зүйлийн 25.6 дахь заалтыг тус тус үндэслэн “Монгол шилтгээн” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 04 сарын 30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2. 500. 000. 100 /хоёр тэр бум, таван зуун сая, нэг зуу / төгрөгийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Г Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17-р зүйлийн 1дэх хэсэг, "Монгол шилтгээн" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 04 сарын 30-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн өрийг хувьцаанд хөрвүүлснээр "Монгол шилтгээн" ХК нь нэг бүр нь 290 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 18. 620. 690 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
2. Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн өрийг хувьцаанд хөрвүүлэх шийдвэр гарсан өдрөөс эхлэн төсөл бүрэн хэрэгжиж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж, компанийн хувьцааны бүртгэл, үнэт цаасны бүрдүүлбэр, дүрэмд орсон өөрчлөлтүүдийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/ Ч.АМАРБААТАР /